

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/01/НА-СТА-ТЕЗ

ТӨВ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2022  
ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [Khishigjargalts@audit.gov.mn](mailto:Khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [Amarjargalo@audit.gov.mn](mailto:Amarjargalo@audit.gov.mn)

Ахлах аудитор Ц.Саранчимэг

Утас: 702723204 Цахим хаяг: [Saranchimegts@audit.gov.mn](mailto:Saranchimegts@audit.gov.mn)

Ахлах аудитор Т.Майцэцэг

Утас: 70273204 Цахим хаяг: [Maitsetsegt@audit.gov.mn](mailto:Maitsetsegt@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

## АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....	3
ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ .....	4
1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН .....	5
1.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан .....	5
1.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан .....	6
1.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
1.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
1.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
1.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	11
2. АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ .....	12
3. АУДИТЫН ТАЙЛАН .....	14
3.1 Ерөнхий зүйл .....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	16
3.4 Материаллаг байдал .....	16
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн.....	16
3.5.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө.....	17
3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт.....	19
3.5.3 Авлага .....	19
3.5.4 Урьдчилгаа .....	20
3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт .....	20
3.5.6 Бараа материал .....	20
3.5.7 Үндсэн хөрөнгө .....	21
3.5.8 Урт хугацаат хөрөнгө оруулалт .....	20
3.5.9 Өр төлбөр .....	23
3.5.10 Урт хугацаат өр төлбөр.....	23
3.5.11 Засгийн газрын хувь оролцоо .....	24
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	24
3.6.1 Төсвийн төлөвлөлт .....	24
3.6.2 Төсвийн гүйцэтгэл .....	25
3.6.3 Нэмэлт төсөв .....	26
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	27

3.8 Аудитын гол асуудал.....	29
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	29
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	29
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....	30
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	30
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	30
4. Аудитын илрүүлэлт .....	31
4.2.1 Залруулсан алдаа .....	31
4.2.2 Төлбөрийн акт .....	32
4.2.2 Албан шаардлага .....	33
4.2.4 Зөвлөмж.....	33
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	35

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

---

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АТБӨЯХАТ	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
БНСБС	Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан
БХНСАХЗ	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал
ДЭХГ	Дулааны эрчим хүчний газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХК	Хувьцаат компани
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМТ	Эрүүл мэндийн төв

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

---

Хүснэгт 1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт.....	17
Хүснэгт 2 Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл .....	17
Хүснэгт 3 Сангуудын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл.....	18
Хүснэгт 4 Авлагын үлдэгдэл .....	19
Хүснэгт 5 Бараа материалын үлдэгдэл.....	20
Хүснэгт 6 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл .....	21
Хүснэгт 7 Богино хугацаат өр төлбөр.....	23
Хүснэгт 8 Урт хугацаат өр төлбөр.....	23
Хүснэгт 9 Нийт Засгийн газрын хувь оролцооны үлдэгдэл .....	24
Хүснэгт 10 Нэмэлт санхүүжилтийн эх үүсвэр .....	27
Хүснэгт 11 Нэмэлт санхүүжилтийн зарцуулалт.....	27
Хүснэгт 12 Төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт.....	28

## 1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

### 1.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		62,869,682	60,615,057
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	3а, 3б	32,396,757	36,943,292
33	<b>АВЛАГА</b>	5а, 5б, 6а, 6б	18,192,919	18,179,444
34	<b>УРЬДЧИЛГАА</b>	7а, 7б	37,700	32,359
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	8а, 8б, 8в	12,211,954	5,446,169
36	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	9а	30,351	13,794
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		222,947,730	107,748,350
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	12а, 12б, 12в	222,947,730	107,748,350
39200	<b>Биет хөрөнгө</b>		210,496,158	99,752,049
39300	<b>Биет бус хөрөнгө</b>	13	12,446,641	7,990,712
39400	<b>Бусад хөрөнгө /ТӨҮГ/</b>	14	4,930	5,590
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>		285,817,411	168,363,408
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		4,045,148	5,803,500
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	15а, 15б	1,891,105	3,953,539
41300	<b>Өглөг</b>	17а, 17б	1,879,575	2,481,618
41400	<b>Урьдчилж орсон орлого</b>	18а, 18б	11,530	1,471,921
42	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		2,154,042	1,849,961
42200	<b>Урт хугацаат зээл</b>	20а, 20б	2,154,042	1,849,961
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		281,772,264	162,559,907
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>		281,772,264	162,559,907
51100	<b>Засгийн газрын оруулсан капитал</b>		75,531,833	32,823,345
51106	<b>Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/</b>		7,153,257	9,378,065
51200	<b>Хуримтлагдсан үр дүн</b>		135,742,367	104,331,842
51300	<b>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</b>		62,584,753	16,026,655
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>		285,817,411	168,363,408

## 1.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		186,255,777.70	128,887,346.20
11	ТАТВАРЫН ОРЛОГО		31,542,089.60	40,427,702.70
110	Орлогын албан татвар		14,661,378.90	18,293,244.10
1100	Хувь хүний орлогын албан татвар		15,243,449.20	18,321,779.20
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-582,070.20	-626,802.80
1103	ААН-ын орлогын албан татвар		0	598,267.60
113	Хөрөнгийн албан татвар		7,095,256.70	11,148,852.70
118	Бусад татвар, төлбөр, хураамж		9,785,454.00	10,985,605.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	122,408,738.60	64,604,069.10
120	Нийтлэг татварын бус орлого		53,907,791.30	42,277,339.10
121	Хөрөнгийн орлого		157,958.60	715,756.40
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		68,342,988.70	21,610,973.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		32,304,949.40	23,855,574.30
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	120,567,318.40	73,473,772.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ		120,321,582.80	67,443,793.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		114,198,034.90	65,521,902.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		52,787,894.90	14,243,921.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		7,257,182.30	1,836,968.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		15,455,441.40	17,795,936.20
2104	Хангамж, бараа материалын зардал		3,135,435.80	1,902,085.20
2105	Нормативт зардал		7,764,213.30	2,921,678.30
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		458,811.60	965,714.10
2107	Томилолт, зочны зардал		180,257.80	186,153.80
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		1,605,834.80	3,753,089.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		25,552,963.00	21,916,355.50
211	ХҮҮ		0	321,830.70
212	ТАТААС		337,291.70	272,050.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		5,786,256.20	1,328,009.50
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		245,735.60	6,029,979.50
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		65,688,459.30	55,413,573.30
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		31,715,710.80	158,208,875.90
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		34,084,173.60	-102,795,302.70

### 1.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	160,177,146.80	112,574,031.00
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	31,534,785.00	41,806,450.30
110	Орлогын албан татвар	14,661,988.70	19,671,991.70
1100	Хувь хүний орлогын албан татвар	15,244,059.00	18,232,466.20
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-582,070.20	-626,802.80
1103	ААН-ын орлогын албан татвар	0	2,066,328.20
113	Хөрөнгийн албан татвар	7,095,256.70	11,148,852.70
118	Бусад татвар, төлбөр, хураамж	9,777,539.50	10,985,605.90
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	994,942.70	1,604,237.60
1181	Газрын төлбөр	3,873,256.40	3,183,899.30
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	4,909,340.40	6,197,469.00
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	98,112,592.60	47,101,240.00
120	Нийтлэг татварын бус орлого	29,611,645.30	24,774,510.00
121	Хөрөнгийн орлого	157,958.60	715,756.40
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	68,342,988.70	21,610,973.60
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	30,529,769.20	23,666,340.80
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	105,128,139.60	60,046,545.60
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	105,128,139.60	60,046,545.60
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	98,842,625.80	57,754,375.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	52,754,709.10	13,504,975.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,260,041.60	2,248,692.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,440,911.00	17,850,355.90
2104	Хангамж, бараа материалын зардал	4,059,770.40	2,653,920.00
2105	Нормативт зардал	4,302,569.60	1,771,927.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	553,134.70	1,022,340.80
2107	Томилолт, зочны зардал	182,152.30	180,538.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,708,199.30	4,046,816.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,581,137.70	14,474,808.60
211	ХҮҮ	0	321,830.70
212	ТАТААС	337,291.70	272,050.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,948,222.10	1,698,288.50
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	55,049,007.20	52,527,485.40
V	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	34,308,591.30	44,834,361.40
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	34,308,591.30	44,834,361.40
2200	Дотоод эх үүсвэрээр	34,308,591.30	44,834,361.40
VI	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	-34,308,591.30	-44,834,361.40
VII	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	-3,453,099.60	-3,146,589.60
23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	3,453,099.60	3,146,589.60
VIII	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	17,287,316.30	4,546,534.40
101	Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эхний үлдэгдэл	15,109,441.10	32,396,757.40
20	Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	32,396,757.40	36,943,291.80



### 1.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	247,565,353.70	247,565,353.70
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	354,995.80	354,995.80
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	247,920,349.50	247,920,349.50
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-313,089.30	-313,089.30
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0
7	Өмчид гарсан өөрчилөлт	80,830.00	80,830.00
8	Зарласан ногдол ашиг	0	0
9	Тайлант үеийн үр дүн	34,084,173.60	34,084,173.60
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	281,772,263.80	281,772,263.80
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	281,772,263.80	281,772,263.80
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-17,976,481.80	-17,976,481.80
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	263,795,781.90	263,795,781.90
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-168.8	-168.8
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-665,111.70	-665,111.70
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0
17	Өмчид гарсан өөрчилөлт	2,224,708.30	2,224,708.30
18	Зарласан ногдол ашиг	0	0
19	Тайлант үеийн үр дүн	-102,795,302.70	-102,795,302.70
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	162,559,907.10	162,559,907.10

1.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	78,859,238.00	64,377,742.20
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	40,972,793.30	37,806,960.13
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	38,847,294.00	36,554,927.99
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	11,749,898.20	11,014,911.83
210101	Үндсэн цалин	8,556,242.10	8,238,360.51
210102	Нэмэгдэл	2,305,189.50	1,874,784.09
210103	Унаа хоолны хөнгөлөлт	148,708.50	170,627.64
210104	Урамшуулал	552,165.60	552,074.89
210105	Гэрээт ажлын хөлс	187,592.50	179,064.71
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	1,552,308.40	1,377,106.09
210201	Тэтгэврийн даатгал	1,084,566.20	951,752.59
210202	Тэтгэмжийн даатгал	117,188.10	109,144.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	93,218.50	86,443.04
210204	Ажилгүйдлийн даатгал	23,606.00	21,121.94
210205	Эрүүл мэндийн даатгал	233,729.60	208,644.31
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	14,413,438.60	13,654,900.72
210301	Гэрэл, цахилгаан	1,475,134.00	1,416,196.34
210302	Түлш, халаалт	12,561,101.90	11,912,164.57
210303	Цэвэр, бохир ус	376,463.50	325,800.61
210304	Байрны түрээс	739.20	739.20
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,052,378.50	1,013,226.56
210401	Бичиг хэрэг	104,467.80	106,804.95
210402	Тээвэр, шатахуун	602,178.10	599,114.63
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	94,152.30	88,683.27
210404	Ном, хэвлэл	1,700.00	1,413.10
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	239,150.00	206,468.61
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,730.30	10,742.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	155,476.80	153,795.21
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	132,000.00	131,850.17
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	23,476.80	21,945.04
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	598,273.30	583,755.59
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,023.00	10,022.19
210604	Урсгал засвар	588,250.30	573,733.40
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	184,340.90	179,562.60
210702	Дотоод албан томилолт	184,340.90	179,562.60
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,407,224.70	3,226,993.16
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,318,091.60	3,148,459.64
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	18,467.50	17,622.00
210803	Даатгалын үйлчилгээ	16,338.50	14,351.63
210804	Тээврийн хэрэгслийн татвар	17,239.90	13,133.60
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	6,180.30	4,468.87
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	26,956.70	26,104.42
210807	Газрын төлбөр	3,800.20	2,704.71
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	150.00	148.30
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	5,733,954.60	5,350,676.23
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,579,933.30	5,210,306.59
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	154,021.30	140,369.65
<b>211</b>	<b>ХҮҮ</b>	1,066,230.00	321,830.73
<b>2112</b>	<b>Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр</b>	1,066,230.00	321,830.73
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	1,066,230.00	321,830.73
<b>212</b>	<b>ТАТААС</b>	272,050.80	272,050.80
<b>2121</b>	<b>Төрийн өмчит байгууллагад олгох татаас</b>	272,050.80	272,050.80
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	272,050.80	272,050.80
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	787,218.50	658,150.61
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	787,218.50	658,150.61
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	151,139.40	70,585.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,000.00	1,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	496,869.80	464,930.03
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	138,209.30	121,635.58
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	33,638,768.10	24,729,381.14
220001	Барилга байгууламж	12,982,252.20	9,339,143.93
221001	Их засвар	10,203,495.10	8,342,416.74
222001	Тоног төхөөрөмж	3,055,857.40	2,384,878.87
223001	Бусад хөрөнгө	7,397,163.40	4,662,941.60
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	4,247,676.60	1,841,400.93
230001	Эргэж төлөгдөх зээл	4,247,676.60	1,841,400.93
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	78,859,238.00	64,794,709.47
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	12,524,291.30	12,408,347.68
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	12,524,291.30	12,408,347.68
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	46,721,228.50	49,993,409.71

**Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

320001	Орон нутгийн төсвөөс	46,721,228.50	49,993,409.71
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>19,613,718.20</b>	<b>2,392,952.08</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,259,676.60	2,370,358.67
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	22,593.41
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	15,354,041.60	0.00
350004	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	0.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	0.00	5,981,454.46
5	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	0.00	6,096,855.94
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>1,932.00</b>	<b>1842</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>62</b>	<b>62</b>
610001	Төсвийн байгууллага	62	62
610002	Төсвөөс гадуур байгууллага	0	0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>935</b>	<b>890</b>
620001	Удирдах ажилтан	252	218
620002	Гүйцэтгэх ажилтан	395	390
620003	Үйлчлэх ажилтан	119	133
620004	Гэрээт ажилтан	169	149
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>935</b>	<b>890</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	408	371
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	4	4
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	340	315
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	183	178

1.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>10,505,072.0</b>	<b>5,618,532.8</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,413,017.3	4,717,313.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,688,913.0	2,901,583.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	358,446.5	27,949.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,263.9	3,477.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	187,344.0	35,925.7
2104	Хангамж, бараа материалын зардал	416,824.5	68,941.7
2105	Нормативт зардал	971,631.9	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	306,294.0	440,546.6
2107	Томилолт, зочны зардал	10,676.2	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	458,625.6	57,495.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,939,806.5	2,267,247.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,724,104.3	1,815,730.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,234,730.7	697,156.3
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	489,373.6	1,118,573.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	92,054.7	901,218.9
2200	Дотоод эх үүсвэрээр	92,054.7	901,218.9
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>10,563,413.4</b>	<b>5,560,188.6</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,563,413.4	5,560,188.6
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>58,341.4</b>	<b>(58,344.2)</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2.8	58,344.2
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	58,344.2	-

## 2. АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ



### ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Хаяг: тусуудан: tov@audit.gov.mn  
Цахиаг хаяг: www.audit.mn

2023.04.20 № 01/274  
Танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  
Д.МӨНХБААТАР ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаар "Төв аймгийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэх тухай" 01 дугаар тогтоолоор 90,98 хувийн гүйцэтгэлтэй буюу "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж дүгнэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2022 оны А/55 тоот захирамжаар 2022 оныг "Ногоон хөгжил, баялаг бүтээгчийг дэмжих" жил болгон зарлаж, удирдлага зохион байгуулалт, ногоон хөгжил, баялаг бүтээгчдийг дэмжих чиглэлээр 3 зорилт 56 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг батлан 90,1 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн ажилласан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн харьяа 64 төсөвт байгууллага, 4 хувийн өмчит сургууль, цэцэрлэг, 10 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 103 тусгай сан, 28 төрийн сангийн нэгж, 4 данс, бусад сайдын багцын 130 төсвийн байгууллага нийт 343 тайлан нэгтгэгдсэнээс Төрийн аудитын газар нь 65 төсөвт байгууллага, 103 тусгай зориулалттай сан, 8 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 27 сумын төсвийн төвлөрүүлэн захирагч, нийт 203 санхүүгийн тайланд аудит хийсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн Жаргалант сумын Эхотөв Жаргалант ОНӨААТҮГ нь үйл ажиллагаа явуулаагүй, Сэргэлэн, Алтанбулаг сумдад шинээр байгуулагдсан ОНӨААТҮГ-ууд нь аудит хийгдэх жагсаалтад бүртгүүлээгүй тул аудитад хамрагдаагүй болно.

G/Архив/Албан бичиг 2023/ А4

19020478

#### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна. Үүнд:

- Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна.
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20, 21, 22 дугаар зүйлд заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчийн боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын байгууллагын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар, үйлчилгээний чиг үүргийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, бусад урсгал зардлуудыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр өөрчлөлт орсон байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал гараагүй болно. Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

#### **Санхүүгийн тайланд төсвийн ерөнхийлөн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

G/Архив/Албан бичиг 2023/ А4

### 3. АУДИТЫН ТАЙЛАН

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар танд танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өмнөх онд аудитлагдсан санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үлдэгдэл, шилэн дансны мэдээлэлтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Саранчимэг Т.Майцэцэг, аудитор Г.Баянжаргал, Д.Бямбасүрэн, Ж.Бямбацогт, Т.Хүрэлбаатар нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт аймгийн Засаг даргын 2023 оны 04 дугаар сарын 03-ны өдрийн 01/567 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч бөгөөд Засаг дарга нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д “Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, түүнчлэн тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн” гэж заасан ба мөн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д “Сумын Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 59.1.1-59.1.23-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлдэг байна.

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 14 дүгээр хуралдааны “Төв аймгийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэх тухай” 01 тоот тогтоолоор 52 зорилт, 257 арга хэмжээний хэрэгжилтийг 90,98 хувийн гүйцэтгэлтэй буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэсэн байна.

Төв аймаг нь 2022 оныг “Ногоон хөгжил, баялаг бүтээгчийг дэмжих” жил болгон зарлаж 56 арга хэмжээ төлөвлөн 90,1 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Аймгийн Засаг даргын 2022 оны А/55 тоот захирамжаар “Ногоон хөгжил, баялаг бүтээгчийг дэмжих” урианы, жилийн төлөвлөгөөг удирдлага зохион байгуулалтын чиглэлээр, ногоон хөгжлийн чиглэлээр, баялаг бүтээгчдийг дэмжих чиглэлээр 3 зорилт 56 арга хэмжээг баталсан байна.

Төв аймгийн 2022 онд “Ногоон хөгжил, баялаг бүтээгчийг дэмжих” урианы жилийн ажлын хүрээнд хийгдсэн ажлаас дурдъя. Үүнд:

1. “Ногоон хөгжил-Баялаг бүтээгчдийг дэмжих” урианы жилийн хүрээнд хийх ажлын төлөвлөгөөний зорилт, арга хэмжээг холбогдох бодлогын баримт бичгүүдэд тусган хэрэгжилтийг хангаж ажилласан байна.
2. Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг өрнүүлэн, аймгийн хэмжээнд 2030 он хүртэл 20 сая мод тарих төлөвлөгөөг боловсруулсан. Байгалийн бүс, бүслүүрийн онцлогт тохируулан

тарьц суулгацыг сонгох, тарих, арчилж хамгаалах чиглэлээр TBS телевиз, телевизийн нэвтрүүлгийг бэлтгэн олон нийтэд хүргэсэн.

3. Мод үржүүлгийн газрыг дэмжин ажиллах ажлын хүрээнд 2022 онд Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд мод үржүүлэг, жимс жимсгэнийн зориулалтаар 19 суманд 107 нэгж талбарын 961,86 га газар эзэмшүүлэхээр төлөвлөснөөс 10 сумын 14 нэгж талбарын 267,71 га газрыг эзэмшүүлсэн байна. 2022 онд БХНСАХ-ний 20.0 сая төгрөгийн хөрөнгөөр ногоон байгууламж, хүнсний ногооны усалгаанд ашиглах зорилгоор Ар бүрдийн нуурыг сэргээн, тус нуурыг түшиглэн 20 га газрыг хашаажуулан, 9 төрлийн 8000 орчим мод, бут тарьсан. Лүн, Эрдэнэ сумдад мод үржүүлгийн газар шинээр байгуулагдсанаар аймгийн хэмжээнд 31 мод үржүүлгийн газрын үйл ажиллагаа жигдэрч 1-6 настай 10.7 сая тарьц суулгацын нөөцийг бүрдүүлээд байна. 1364 аж ахуйн нэгж байгууллага, 8468 иргэдийн оролцоотойгоор 1172282 ширхэг мод бут сөөг тарьж ургуулсан байна.
4. Цар тахлын улмаас үүссэн эдийн засгийн хямралыг даван туулахад баялаг бүтээгчдийг дэмжин дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, үйлдвэрлэл үйлчилгээний салбарын тогтвортой байдлыг хангах, монгол улсын засгийн газраас зарласан 2022 оны “хоршоо хөгжлийг дэмжих” жилийн хүрээнд хоршооны үйл ажиллагааг дэмжин ажилласан байна.

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажилласан байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг дагаж батлагдсан Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, газрын төлбөр, цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдуулсан хувь хүний орлогын албан татварын орлогыг сумын төсөвт төвлөрүүлэхээр болж, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20-22 дугаар зүйлд заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчийн боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын байгууллагын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар, үйлчилгээний чиг үүргийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, бусад урсгал зардлуудыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр өөрчлөлт орсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн төсвийн байгууллага, төсөл сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэхэд мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг аймгийн Засаг даргын 2021 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн А/243 тоот захирамжаар баталсан ч Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь хэвлэгдээгүйгээс шалтгаалан бүрэн хэрэгжих боломжгүй байна.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйл, 36 дугаар зүйлийн 36.6-д заасны дагуу төрийн сангийн дотоод хяналтын мэргэжилтэн төрийн сангийн үйл ажиллагаанд, Санхүүгийн хяналт, аудитын алба төсвийн орлого, зарлагын үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хэрэгжүүлэн ажилладаг байна.

Тайлант онд Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.6- д “Төв төрийн сан нь аймаг, нийслэлийн төрийн сан болон төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгжийн үйл ажиллагаанд, аймаг, нийслэлийн төрийн сан нь сум, дүүргийн төрийн сангийн үйл ажиллагаанд санхүүгийн дотоод хяналтыг тус тус хэрэгжүүлнэ”, Сангийн сайдын 2014 оны 65 тоот тушаалаар баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын



журам"-ыг үндэслэн аймгийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 8-ны өдрийн А/64 тоот захирамжаар Алтанбулаг, Аргалант, Батсүмбэр, Баян, Баяндэлгэр, Баянцагаан, Баянжаргалан, Борнуур, Жаргалант, Мөнгөнморьт зэрэг нийт 10 сумын төрийн сангийн нэгжид дотоод хяналтыг хэрэгжүүлэхээр батлуулсан байна. Шалгалтаар санхүүгийн албаны дарга нар мэргэжил арга зүйгээр хангаж, санхүүгийн ажилтнуудад шаардлага, хяналт тавьж ажилладаггүй, зарлагын гүйлгээний хяналтыг тогтмол хэрэгжүүлдэггүй, төрийн сангийн ажилтнууд тогтвор суурьшилтай ажилладаггүй, төсвийн шууд захирагч нар төсөв санхүүтэй холбоотой эрх зүйн мэдлэг хангалтгүй, эд хариуцагч нарын үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй дутагдал нийтлэг байгааг талаар дүгнэлт гаргасан байна. Цаашид анхаарах асуудлаар сумдад 16 зөвлөмжийг хүргүүлж ажилласан байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэд Санхүү хяналт, дотоод аудитын албыг 7 орон тоотойгоор байгуулж, тус албаны дүрмийг батлан хяналт, шалгалтыг хийж шалгагдагч байгууллага болон дотоод аудитын хороонд тайлагнадаг байна.

Санхүүгийн хяналт шалгалтын 2022 оны төлөвлөгөөний дагуу 13 сумын 91, аймгийн төвийн 19, ОНӨҮГ 4, аймгийн Засаг даргын тусгай удирдамжаар 2 нийт 122 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийсэн байна. Мөн сумдын эмийн эргэлтийн сан, сум хөгжүүлэх сан, орон нутгийн хөгжлийн сан, шилэн дансны үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийж, шалгалтын дүнг дотоод аудитын хороогоор хэлэлцүүлэн сумд байгууллагын удирдлагуудад зөвлөмж гарган хүргүүлж ажилласан байна.

Аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэгийг жилд 2 удаа тусгай удирдамж төлөвлөгөөний дагуу бүх сум байгууллагуудад хийж, зөвлөн тусалдаг байна.

Төв аймгийн Засаг даргын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төлөвлөгөөний нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төлөвлөгөөний нийт зарлага 79,453.7 сая төгрөгөөс 1,5 хувиар буюу 1,191.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75,0 хувиар буюу 893.8 сая төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн**

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн

захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 117,461.4 сая төгрөгөөр буюу 58,9 хувиар буурсан байна. Энэ нь байгууллагууд улсын төсвийн байгууллага руу шилжиж Төсвийн тухай хуулийн дагуу жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргахдаа Сангийн сайдын 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 10/84 тоот албан бичгээр өгсөн заавар, аргачлал, чиглэлийг баримталсантай холбоотойгоор буурсан байна.

Хүснэгт №1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	32,396.8	36,943.3	4,546.5
Авлага	18,200.3	18,179.4	-20.9
Урьдчилгаа	37.7	32.3	-5.4
Бараа материал	12,211.9	5,446.2	-6,765.7
Нөөцийн бараа	30.4	13.8	-16.6
Үндсэн хөрөнгө	222,947.7	107,748.4	-115,199.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>285,824.8</b>	<b>168,363.4</b>	<b>-117,461.4</b>
Өр төлбөр	4,052.5	5,803.5	1,751.0
Засгийн газрын хувь оролцоо	281,772.3	162,559.9	-119,212.4
<b>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>	<b>285,824.8</b>	<b>168,363.4</b>	<b>-117,461.4</b>

Эх сурвалж: Төв аймгийн ТЭЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаас

3.5.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлангаар мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 32,396.7 сая төгрөг, тайлант оны үйл ажиллагааны мөнгөн орлого 204,305.5 сая төгрөг төвлөрч, харьяа байгууллагуудын урсгал санхүүжилтэд 151,584.2 сая төгрөгийг, хөрөнгө оруулалтын санхүүжилтэд 45,028.2 сая төгрөгийг, эргэн төлөгдөх зээлд 3,146.6 сая төгрөгийг зарцуулж, оны эцсийн үлдэгдэл 36,943.3 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө тайлагнагдсан байна.

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 32,396.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 36,943.3 сая төгрөг болж, 4,546.6 сая төгрөгөөр өссөн байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 4,546.6 сая төгрөгөөр өссөн нь орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл 6,550.8 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны жилийн эцсийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 98.1 хувь буюу 36,231.3 сая төгрөг нь төрийн сангийн харилцах дансанд, 1.9 хувь буюу 703.5 сая төгрөг нь арилжааны банк дахь харилцах дансанд, 8.4 сая төгрөг нь байгууллагуудын кассад байршиж байна.

Хүснэгт №2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	0.7	8.4	7.7
Төрийн сангийн харилцах	31,928.8	36,231.3	4,302.5
Нэмэлт дансны харилцах	58.3		-58.3
Банканд байгаа бэлэн мөнгө	408.9	703.5	294.6
<b>Дүн</b>	<b>32,396.7</b>	<b>36,943.3</b>	<b>4,546.6</b>
<i>Үүнээс: байгууллагын төрлөөр</i>			
Орон нутгийн ерөнхий орлого	17,225.8	23,776.6	6,550.8
Сумын орлогын дүн	6,763.9	14,869.9	8,106.0

Аймгийн ерөнхий орлогын дүн	10,461.9	8,906.7	-1,555.2
Төсөвт байгууллага	494.2	804.1	309.9
Төсөл/ сан	14,660.8	12,232.8	-2,428.0
ТӨҮГ болон ОНӨҮГ	16.0	129.8	113.8
<b>Дүн</b>	<b>32,396.7</b>	<b>36,943.3</b>	<b>4,546.6</b>

Эх сурвалж: Төв аймгийн ТЭЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаас

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төрийн сангийн харилцах дансанд байршиж буй 36,231.3 сая төгрөгийн үлдэгдлээс 23,776.6 сая төгрөг нь орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл, 11,664.8 сая төгрөг нь сангуудын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, 58.8 сая төгрөг нь БаруунЗуунмод Өрхийн эрүүл мэндийн төвийн, 731.1 сая төгрөг нь нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлсэн үлдэгдэл байна.

2022 оны жилийн эцсийн кассын үлдэгдэл нийт 8.4 сая төгрөгийг Эмийн эргэлтийн сан, Заамарын хөгжил, Тариалан дэмжих сангийн үлдэгдэл эзэлж байна.

Орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл 6,550.8 сая төгрөгөөр өссөн нь аймаг, сумын орлогын үлдэгдэл, орон нутгийн буцаан төвлөрүүлсэн мөнгөтэй холбоотой байна.

### Сангуудын мөнгөн хөрөнгө

Тусгай зориулалттай сангуудын мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийн бүтцийг авч үзэхэд Төрийн сангийн харилцах дансанд 11,664.8 сая төгрөг, арилжааны банк дахь харилцах дансанд 567.2 сая төгрөг, касс бэлэн мөнгө дансанд 0.8 сая төгрөг тус тус байршиж байна.

Хүснэгт №3. Сангуудын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Касс байгаа мөнгө	Банк дахь бэлэн мөнгө	
				Арилжааны банк	Төрийн сан
Эмийн эргэлтийн сан	378.7	562.9	0.2	562.7	-
Орон нутгийн хөгжлийн сан	3,957.6	3,844.2	-	-	3,844.2
Сум хөгжүүлэх сан	1,698.4	2,209.2	-	-	2,209.2
Байгаль хамгаалах сан	347.2	377.1	-	-	377.1
Мал хамгаалах сан	102.0	83.8	-	-	83.8
Хөрөнгө оруулалт, хөгжлийн барьцаа сан	7,829.8	4,327.3	-	-	4,327.3
Тариалан дэмжих сан	0.6	0.6	0.6	-	-
Аймаг хөгжүүлэх сан	339.1	820.2	-	4.5	815.7
Хөрөнгө, оруулалт	7.4	7.4	-	-	7.4
<b>Дүн</b>	<b>14,660.8</b>	<b>12,232.8</b>	<b>0.8</b>	<b>567.2</b>	<b>11,664.8</b>

Эх сурвалж: Төв аймгийн ТЭЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаас

Тайлант онд сангуудын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2,428.0 сая төгрөгөөр буурсан нь орон нутгийн хөгжлийн сан 113.4 сая төгрөг, мал хамгаалах сан 18.2 сая төгрөг, барьцаа сан 3,502.4 сая төгрөгөөр буурснаас нөлөөлсөн байна.

Эмийн эргэлтийн сан 184.2 сая төгрөг, сум хөгжүүлэх сан 510.8 сая төгрөг, байгаль хамгаалах сан 29.9 сая төгрөг, аймаг хөгжүүлэх сан тайлант онд 481.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд хөрөнгө оруулалт, хөрөнгийн барьцаа сан өмнөх онд төвлөрүүлсэн ажлын үлдэгдэл санхүүжилтийг гүйцэтгэлээр олгосноос 3,502.4 сая төгрөгөөр буурсан байна.

### Харьяа байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар:

1. Дэлгэрхаан, Алтанбулаг, Архуст, Сэргэлэн, Баянжаргалан, Баянхангай, Зуунмод, Борнуур, Эрдэнэ сумдын Засаг даргын тамгын газар, аймгийн Засаг даргын тамгын газар харилцагч байгууллагатай хийсэн 1,528.3 сая төгрөгийн худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй зөрчилд албан шаардлага, зөвлөмж өгсөн.

2. Заамрын хөгжил ОНӨААТҮГ нь 13 удаагийн 34.7 сая төгрөгийн нэхэмжлэхгүй гүйлгээ хийсэн, худалдан авсан хөрөнгө, материалын дүнг, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын төлбөрийн цахим системийн дүнтэй тулгахад 5 иргэн, байгууллагын 12.1 сая төгрөгөөр дутуу бүртгээгдсэн зөрчилд зөвлөмж өгсөн.

3. Аймгийн Засаг даргын Тамгын газар кассын тайланг сар бүр гаргадаггүй, мөнгөн урьдчилгааны тайлан бэлтгэдэггүй, нэг удаа кассаар гарах мөнгөн дүнгээс өндөр дүнгээр зарлага гаргасан 86.4 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

4. Баян-Өнжүүл, Аргалант, Баянжаргалан, Борнуур, Заамар сумдын Засаг даргын тамгын газар, Эрдэнэ, Өндөрширээт, Аргалант сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Санхүү хяналт дотоод аудитын алба зэрэг байгууллагууд албан томилолт хэтрүүлэн олгосон, кассаар бэлэн мөнгө гаргаж зарцуулсан, төсвийг үрэлгэн зарцуулсан, худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар нийт 48.2 сая төгрөгийн 9 зөрчилд зөвлөмж өгсөн.

6. Бүрэн сумын Засаг даргын тамгын газар, Аргалант, Заамар сумдын Засаг дарга 12.9 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

### 3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт байхгүй.

### 3.5.3 Авлага

Төв аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт авлагын эхний үлдэгдэл 18,192.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 18,179.4 сая төгрөгөөр тайлагнаж өмнөх онтой харьцуулахад 13.5 сая төгрөгөөр буюу 0.07 хувиар буурсан байна.

Хүснэгт №4. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+) Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	89.0	187.3	98.3
Төлбөртэй үйлчилгээний авлага	343.2	3.0	-340.2
Татаас, санхүүжилтийн авлага	3.1	0	-3.1
Зээлийн хүүгийн авлага	85.7	86.0	0.3
Дансны авлага /ТӨҮГ/	5.6	4.6	-1.0
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	13.4	31.7	18.3
Бусад авлага	15,519.8	16,025.8	506.0
Зээлийн авлага	2,133.1	1,841.0	-292.1
<b>Дүн</b>	<b>18,192.9</b>	<b>18,179.4</b>	<b>-13.5</b>
<i>Үүнээс: байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	2,831.7	10,872.9	-8,041.2
Төсөл/ сан	12,505.5	4,619.7	7,885.8
Төрийн сан	2,144.3	1,850.3	-294.0
ТӨҮГ болон ОНӨҮГ	711.4	836.5	125.1
<b>Дүн</b>	<b>18,192.9</b>	<b>18,179.4</b>	<b>-13.5</b>

Эх сурвалж: Төв аймгийн ТЕЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаас

Байгууллагын төрлөөр авч үзвэл төсөвт байгууллагын авлага өмнөх оноос 8,041.2 сая төгрөг буюу 3.8 дахин, төрийн сан дахь ОНӨО-ын авлага 294.0 сая төгрөг буюу 13.7 хувиар буурсан бөгөөд төсөл, сан 7,885.8 сая төгрөг буюу 63,06 хувиар ОНӨААТҮГ-ын авлага 125.1 сая төгрөг буюу 17,6 хувиар өссөн байна.

Тайлант онд авлагын эцсийн үлдэгдэл 117 байгууллагатай холбоотой үүссэн 18,179.4 сая төгрөгийн бүтцийг харуулбал:

- 138.6 сая төгрөг буюу 0,8 хувийг Эмийн эргэлтийн сан
- 1,723.6 сая төгрөг буюу 9,5 хувийг Орон нутгийн хөгжлийн сан
- 7,659.3 сая төгрөг буюу 42,1 хувийг Хоршоо хөгжүүлэх сан
- 79.6 сая төгрөг буюу 0,4 хувийг Тариалан эрхлэлтийг дэмжих сан
- 4,537.3 сая төгрөг буюу 25,0 хувийг Аймаг хөгжүүлэх сан
- 176.7 сая төгрөг буюу 0.9 хувийг Мал хамгаалах сан

- 1,850.3 сая төгрөг буюу 10,2 хувийг төрийн сан
- 836.5 сая төгрөг буюу 4,6 хувийг ОНӨААТҮГ-ын авлага
- 1,177,5 сая төгрөг буюу 6,5 хувийг бусад төсөвт байгууллагуудын авлага тус тус эзэлж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн 1,723.6 сая төгрөгийн авлага нь хөрөнгө оруулалтын ажил бүрэн хийгдэж хүлээн аваагүйгээс үүссэн 22 байгууллагын авлага байна.

Төсөвт байгууллагуудын авлагад хоршоо хөгжүүлэх сан, орон нутгийн хөгжлийн сан, эмийн эргэлтийн сан, болон бусад төсөвт байгууллагуудын авлагыг нэгтгэж тайлагнасан байна.

ОНӨААТҮГ-ын авлагын 83.3 хувь буюу 696.5 сая төгрөг нь Төв Чандмань ДЭХГ-ын байгууллагаас авах авлага 664.8 сая төгрөг, татвар НДШ-ийн авлага 31.7 сая төгрөг байна.

**Харьяа байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар:**

1.Харилцагч байгууллагатай авлагын тооцоо үүсгээгүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй Угтаалцайдам, Аргалант сумдын ЗДТГ, Лүн сумын ИТХ, сум дундын ойн анги, Баянцагаан сумын эмийн эргэлтийн сан, Заамрын хөгжил ОНӨААТҮГ зэрэг 6 байгууллагын 69.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн байна.

2.Төсвийн жил дуусч байгаатай холбогдуулан төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг харилцагч, бэлтгэн нийлүүлэгч байгууллага руу шилжүүлэн авлага үүсгэсэн, насжилт өндөртэй авлагыг барагдуулаагүй байгаа зэрэг Жаргалант, Дэлгэрхаан, Лүн, Угтаалцайдам, Аргалант сумдын ЗДТГ, Борнуур, Бүрэн сумдын ИТХ-ын 7 байгууллагын 18.6 сая төгрөгийн зөрчилд 8 төлбөрийн акт тогтоосон байна.

3.Тайлант оны авлагыг зөрүүтэй тайлагнасан Батсүмбэр сум дахь сум дундын ойн анги, орон нутгийн өмчийн газар 2 байгууллагад 88.7 сая төгрөгийн зөвлөмж өгөгдсөн байна.

**3.5.4 Урьдчилгаа**

Урьдчилгаа дансны оны эхний үлдэгдэл 37.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 33.0 сая төгрөг болж, 4.7 сая төгрөгөөр буурсан байна. Урьдчилгаа дансны үлдэгдэл 37.7 сая төгрөг нь орон нутгийн өмчит Төв Чандмань ДЭХГ-ын нүүрс бэлтгэхтэй холбоотой бэлтгэн нийлүүлэгчид шилжүүлсэн төлбөрийн үлдэгдэл байна.

**3.5.5 Бараа материал**

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дах бараа материалын эцсийн үлдэгдэл 5,460.0 сая төгрөг болж, оны эхнээс 6,782.3 сая төгрөгөөр буурсан байна.Бараа материалын тодруулгаар тайлант онд 19,585.6 сая төгрөгөөр нэмэгдэж, 26,367.9 сая төгрөгөөр хасагдсан байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Бараа материал	12,211.9	5,446.2	-6,765.7
Тусгай зориулалттай материал	1,557.3	419.9	-1,137.4
Эм боох материал	2,543.7	914.7	-1,629.0
Дуусаагүй үйлдвэрлэл	76.0	26.0	-50.0
Бэлэн бүтээгдэхүүн	57.7	53.5	-4.2
Бичиг хэргийн материал	194.9	65.6	-129.3
Аж ахуйн материал	2,809.9	1,160.8	-1,649.1
Сэлбэг хэрэгсэл	185.5	293.9	108.4
Түлш, шатах тослох материал	78.9	42.8	-36.1
Барилгын засварын материал	55.9	15.0	-40.9
Хүнсний материал	216.8	13.5	-203.3
Бусад хангамжийн материал	4,224.5	2,195.6	-2,028.9
Биологийн хөрөнгө	7.7	7.7	0.0
Мал амьтад	203.1	237.2	34.1

Нөөцийн бараа	30.4	13.8	-16.6
Тэжээлийн нөөц	9.0	9.0	0.0
Бусад нөөц	21.4	4.8	-16.6
<b>Дүн</b>	<b>12,242.3</b>	<b>5,460.0</b>	<b>-6,782.3</b>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр:</i>			
Төсөвт байгууллага	9,788.9	3,758.9	-6,030.0
Төсөл/ сан	1,079.0	1,261.2	182.2
Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	1,374.4	439.9	-934.5
<b>Дүн</b>	<b>12,242.3</b>	<b>5,460.0</b>	<b>-6,782.3</b>

Эх сурвалж: Төв аймгийн ТЭЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаас

Нийт бараа материалыг байгууллагын бүтцээр нь авч үзвэл 3,758.9 сая төгрөг буюу 68,8 хувийг төсөвт байгууллага, 1,261.2 сая төгрөг буюу 23,1 хувийг төсөл сан, 439.9 сая төгрөг буюу 8,1 хувийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн бараа материал эзэлж байна. Бараа материалын үлдэгдэл 6,782.3 сая төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын 6,696.4 сая төгрөгийн бараа материалыг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.

Харьяа байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар:

1. Лүн суман дахь сум дундын ойн анги, Сэргэлэн сумын Засаг даргын тамгын газар бараа материалын үлдэгдлийн тооллого хийж тооцоо бодоогүй, Аргалант, Цээл, Баянцагаан сумдын Эмийн эргэлтийн сангийн бараа материалын дэлгэрэнгүй бүртгэл байхгүй, тооллогын бүртгэл байхгүй 249,1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, зөвлөмж өгсөн.
2. Баян-Өнжүүл, Эрдэнэсант, Эрдэнэ сумдын Засаг даргын тамгын газар шатахууны тооцоо бодоогүй болон дутуу бодогдсон 70.7 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.
3. Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын тамгын газар мал амьтадын дансанд бүртгэлтэй 23.9 сая төгрөгийн 280 толгой малын нэг бүрийн үнэ нь 10.0 мянган төгрөгөөс 100.0 мянган төгрөгийн бодит биш үнэлгээтэй, төсвийн хөрөнгийг хэт үнээгүйдүүлж байгаа зөрчилд зөвлөмж өгсөн.
4. Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын шатахууны зардал өмнөх оноос 12.9 сая төгрөгөөр өссөн зөрчилд зөвлөмж өгсөн.
5. Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын тамгын газар ОНХС-гийн хөрөнгөөр авсан малыг гэрээгээр эзэмшүүлсэн гэх боловч хэнд байгаа нь тодорхойгүй, гэрээг дүгнэсэн баримтгүй 17.2 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.
6. Төв Эрдэнэс ОНӨААТҮГ, Батсүмбэр, Аргалант сумдын Засаг даргын тамгын газар, Орон нутгийн өмчийн газрын 2.5 сая төгрөгийн бараа материалын тооллого хийгээгүй, шатахууны тооцоо бодоогүй 5 зөрчилд зөвлөмж өгсөн.

### 3.5.6 Үндсэн хөрөнгө

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 107,748.3 сая төгрөг болж, өмнөх оноос 115,199.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №6 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	163,977.3	57,973.0	-106,004.3
Авто-тээврийн хэрэгсэл	4,227.6	5,865.0	1,637.4
Машин тоног төхөөрөмж(компьютер)	9,957.1	7,413.2	-2,543.9
Тавилга, аж ахуйн эд хогшил	3,598.8	992.2	-2,606.6
Зам, гүүрний байгууламж	13,787.5	13,009.8	-777.7
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	926.1	31.1	-895.0
Бусад үндсэн хөрөнгө	11,543.0	12,661.8	1,118.8
Дуусаагүй барилга, байгууламж	1449.3	1494.5	45.2
Ном	1029.5	311.3	-718.2
Программ хангамж	133.9	116.6	-17.3

Бусад биет бус хөрөнгө	12,312.7	7,874.1	-4,438.6
Биологийн хөрөнгө /ТӨҮГ/	4.9	5.6	0.7
<b>Дүн</b>	<b>222,947.7</b>	<b>107,748.3</b>	<b>-115,199.4</b>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	206,269.8	89,189.0	-117,080.8
Төсөл/ сан	51.6	66.1	14.5
ТӨҮГ болон ОНӨҮГ	16,626.3	18,493.2	1,866.9
<b>Дүн</b>	<b>222,947.7</b>	<b>107,748.3</b>	<b>-115,199.4</b>

Эх сурвалж: Төв аймгийн ТЕЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаас

Үндсэн хөрөнгө дансны жилийн эцсийн хөрөнгийн үлдэгдлийн 77.8 хувь буюу 83,818.1 сая төгрөгийг сумын ЗДТГ, 0,2 хувь буюу 250.4 сая төгрөгийг Иргэдийн төлөөлөгчдийн хурал, бусад төсөвт байгууллага 4,8 хувь буюу 5,120.5 сая төгрөг, 0,03 хувь буюу 40.3 сая төгрөгийг эмийн эргэлтийн сангийн хөрөнгө, 0,02 хувь буюу аймаг хөгжүүлэх болон сум хөгжүүлэх сан 25.8 сая төгрөг, 17.2 хувь буюу 18,493.2 сая төгрөгийн хөрөнгийг Орон нутгийн өмчит газрууд эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн тодруулга тайлангаар тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 3,880.0 сая төгрөг, үнэ төлбөргүй хандиваар авсан 5,920.3 сая төгрөг, балансаас баланст шилжүүлэн авсан 3,602.7 сая төгрөг, бусад 12,583.9 сая төгрөгөөр нийт 25,986.9 сая төгрөгөөр нэмэгдсэн, эрх бүхий байгууллагын шийдвэрээр худалдан борлуулсан 7.6 сая төгрөг, акталж данснаас хассан 1,701.5 сая төгрөг, балансаас баланст шилжүүлсэн 1,316.6 сая төгрөг, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн 158,323.5 сая төгрөг, бусад 231,4 сая төгрөг, дахин үнэлгээний хорогдол 12.1 сая төгрөг, нийт 161,592.7 сая төгрөгөөр хасагдсан байна.

Үндсэн хөрөнгө дансанд бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн 158,323.5 сая төгрөг нь Ерөнхий боловсролын сургуулийн 70,851.7 сая төгрөгийн, Цэцэрлэгийн 28,091.9 сая төгрөгийн, Эрүүл мэндийн төвийн 19,138.8 сая төгрөгийн, Соёлын төвийн 17,837.7 мянган төгрөгийн, бусад байгууллагууд 22,403.4 сая төгрөгийн хөрөнгө эзэлж байна.

Дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй нийт 1,494.5 сая төгрөгийн хөрөнгө нь Угтаалцайдам сумын Засаг даргын Тамгын газрын 58.0 сая төгрөгийн 24 айлын орон сууц, Баян сумын Засаг даргын Тамгын газрын 297.5 сая төгрөгийн авто зам, Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газрын 15.1 сая төгрөгийн ногоон байгууламж, Төв Чандмань ДЭХГ-ын 1,123.8 сая төгрөгийн Дулааны станцын барилга байна.

Харьяа байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар:

1. Алтанбулаг, Сэргэлэн, Зуунмод, Архуст сумдын Засаг даргын тамгын газарт элэгдлээрээ өртгөө нөхсөн 1,609.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн дансны 4 зөрчилд зөвлөмж өгсөн.
2. Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын тамгын газар үндсэн хөрөнгө дансанд зам гүүрний барилга байгууламж дансанд зам засварын орлогыг 15.0 сая төгрөгөөр, бусад үндсэн хөрөнгө дансанд зам сайжруулалтыг 15.0 сая төгрөгөөр гэх мэтээр ижил төрлийн хөрөнгийг өөр өөр дансанд бүртгэсэн зөрчилд зөвлөмж өгсөн.
3. Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын Тамгын газар тайлант онд 100.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгөнд 0.8 сая төгрөгийн элэгдэл тооцоогүй зөрчилд албан шаардлага өгсөн.
4. Заамар хөгжил ОНӨААТҮГ 387.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, шийдвэргүй бүртгэсэн зөрчилд албан шаардлага өгсөн.

**3.5.7 Урт хугацаат хөрөнгө оруулалт  
Урт хугацаат хөрөнгө оруулалт байхгүй**

### 3.5.8 Өр төлбөр

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд богино хугацаат өр төлбөр дансны оны эхний үлдэгдэл 1,891.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 3,953.5 сая төгрөг болж, оны эхнээс 2,062.4 сая төгрөгөөр өссөн байна.

Тайлант хугацаанд өр төлбөр дансны үлдэгдэл 2,062.4 сая төгрөгөөр өсөхөд дараах хүчин зүйлс нөлөөлсөн. Үүнд:

- Урьдчилж орсон орлого 1,468.1 сая төгрөг нь 2023 оны аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогоос урьдчилан авснаас шалтгаалсан байна.
- Төв Чандмань ДЭХГ-ын өглөг оны эхэнд 1,070.8 сая төгрөг, оны эцэст 1,311.7 сая төгрөг болж 240.9 сая төгрөгөөр, Төв эрдэнэс ОНӨААТҮГ-ын өглөг оны эхэнд 5.5 сая төгрөг, оны эцэст 85.5 сая төгрөг болж 80.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн
- Тайлант онд үйл ажиллагаагаа эхэлсэн ОНӨААТҮГ-уудад 314.6 сая төгрөгийн өглөг шинээр үүссэн байна. (Заамар хөгжил 12.6 сая төгрөг, Сэргэлэн нутгийн хөгжил 6.8 сая төгрөг, Эрдэнэ тохижилт үйлчилгээ 0.1 сая төгрөг, Зуунмод цэцэрлэгжүүлэлт 295.2 сая төгрөг )

Хүснэгт №7 Богино хугацаат өр төлбөр

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт +/- Бууралт /-/
Ажилчидтай холбогдсон өглөг	114.1	61.4	(52.7)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	184.4	161.1	(23.3)
Байгууллагад төлөх өглөг	1,168.0	1,816.6	648.6
Хувь хүмүүст төлөх өглөг	3.5	21.5	18.0
Татварын өглөг /ТӨҮГ/	291.4	357.6	66.2
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	118.2	54.0	(64.2)
Дансны өглөг /ТӨҮГ/	-	9.4	9.4
Урьдчилж орсон орлого	11.5	1,471.9	1,460.4
<b>Дүн</b>	<b>1,891.1</b>	<b>3,953.5</b>	<b>2,062.4</b>
Үүнээс: Байгууллагын төрлөөр			-
Төсөвт байгууллага	444.5	402.8	(41.7)
ТӨҮГ болон ОНӨҮГ	1,076.3	1,727.9	651.6
Төрийн сан	0	1,468.1	1,468.1
Төсөл/ сан	370.3	354.7	(15.6)
<b>Дүн</b>	<b>1,891.1</b>	<b>3,953.5</b>	<b>2,062.4</b>

Эх сурвалж: Төв аймгийн ТЭЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаас

#### Харьяа байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар:

1. Харилцагч байгууллагатай өглөгийн тооцоо үүсгээгүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, өглөгийг буруу дансаар бүртгэсэн Лүн, Баянхангай сумдын ЗДТГ, Баруунзуунмод өрхийн ЭМТ 3 байгууллагын 964.1 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлсэн байна

### 3.5.9 Урт хугацаат өр төлбөр

Урт хугацаат өр төлбөр дансны 2022 оны эхний үлдэгдэл 2,154.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 1,850.0 сая төгрөг болж 313.0 сая төгрөгөөр буурсан байна. Засгийн газрын дамжуулан зээлдүүлэх зээлийн үлдэгдэл 1,841.0 сая төгрөг болж, 292.1 сая төгрөгөөр буурч, Төв Чандмань дулааны ДЭХГ-ын эрсдэлийн санд өөрчлөлт ороогүй байна.

Хүснэгт№8 Урт хугацаат өр төлбөр

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт +/- Бууралт /-/
ЗГ-ын дамжуулан зээлдүүлэх зээл	2,133.1	1,841.0	-292.1
Нөөц /өр төлбөр/	20.9	9.0	-11.9
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>2,154.0</b>	<b>1,850.0</b>	<b>-304.0</b>

Эх сурвалж: Төв аймгийн ТЭЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаас



### 3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд цэвэр хөрөнгө, өмч өөрчлөлтийн эхний үлдэгдэл 281,772.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 162,526.0 сая төгрөг болж, оны эхнээс 119,246.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №9 Цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын хувь оролцоо	83,445.2	42,201.4	-41,243.8
Хөрөнгийн дахин үнэлгээний нөөц	62,584.7	16,026.7	-46,588.0
Хуримтлагдсан үр дүн	135,741.5	104,297.9	-31,444.5
<b>Өмчийн дүн</b>	<b>281,772.3</b>	<b>162,526.0</b>	<b>-119,246.3</b>

Эх сурвалж: Төв аймгийн ТЭЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаас

Цэвэр хөрөнгө, өмчийн дүн оны эхний үлдэгдлээс 119,246.3 сая төгрөг буюу 42,3 хувиар буурсан нь Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагуудын санхүүгийн тайланг харьяа улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлсэнтэй холбоотойгоор Засгийн газрын хувь оролцооны 41,243.8 сая төгрөг, хөрөнгийн дахин үнэлгээний нөөцийн 46,588.0 сая төгрөгийг оны эхний үлдэгдлээс шилжүүлж тайлагнасан нь нөлөөлсөн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төв аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн VII хуралдааны “Аймгийн 2022 оны төсөв батлах тухай” 03 дугаар тогтоолоор аймгийн төсөвт төвлөрүүлэх татварын ба татварын бус орлогыг 6,236.0 сая төгрөгөөр, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоолоор сумын төсөвт төвлөрүүлэх орлогыг 25,831.7 сая төгрөгөөр, нийт 32,067.7 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь УИХ-аас аймгийн орон нутгийн төсвийн 2022 оны нийт орлогыг 31,717.7 сая төгрөг байхаар тооцсоноос 350.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Төв аймгийн ИТХ-ын 2022 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн “Аймгийн 2022 оны төсвийн тодотгол батлах тухай” 03 дугаар тогтоол болон сумдын ИТХ-ын төсөв тодотгосон тогтоолд нийт 35,729.7 сая төгрөгөөр батлагдсан нь анхны баталсан төсвөөс 3,661.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Сумдын ИТХ-ын тогтоолоор батлагдсан татварын ба татварын бус орлогыг, Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайланд 19.1 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн зөрчил илэрлээ.

Аймгийн Засаг даргын 2022 онд зарцуулах зарлагын нийт хэмжээг, аймаг, сумдын ИТХ-ийн хуралдаанаар 76,841.5 сая төгрөгөөр баталсныг 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн VIII хуралдааны 16 дугаар тогтоол, 2022 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн X хуралдааны 03 дугаар тогтоолоор тодотгон 78,859.2 сая төгрөгөөр буюу 2,017.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 15 хөтөлбөрт зориулан 78,859.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 40,972.8 сая төгрөгийг урсгал зардалд, 33,638.8 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, эргэж төлөгдөх цэвэр зээлд 4,247.6 сая төгрөг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 12,524.3 сая төгрөгийг улсын төсвөөс буюу орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 46,721.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 15,354.0 сая төгрөгийг урьд оны шилжих үлдэгдлээс, 4,259.7 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлого буюу зээлийн эргэн төлөлтөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор батлагдсан 2022 онд зарцуулах төсвийн зарлагын төлөвлөгөөг э-тайлангийн төлөвлөгөөтэй тулган шалгахад 5 суманд нийт 497.0 сая төгрөг зөрүүтэй байгаа зөрчил илэрсэн. Энэ нь сумдын ИТХ-ын төсөв баталсан тогтоолын өөрчлөлтийг бүрэн тусгадаггүйтэй холбоотой байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд батлагдсан төлөвлөгөөгөөр улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 9,202.6 сая төгрөг, ОНХНС-ийн орлогын шилжүүлэг 12,524.3 сая төгрөг, нийт 21,726.9 сая төгрөг эх үүсвэр бүрдүүлэхээс, ОНХНС-ийн орлогын шилжүүлэг 115.9 сая төгрөгөөр дутуу санхүүжигдсэн байна.

Тусгай зориулалттай сангуудын батлагдсан төлөвлөгөөгөөр 4,259.7 сая төгрөгийн эргэн төлөлт төвлөрүүлэхээс 2,370.4 сая төгрөг бүрдүүлж 2,024.9 сая төгрөгийн эх үүсвэр дутуу бүрдүүлсэн байна.

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогыг аймаг, сумдын ИТХ-ын хуралдаанаас нийт 35,729.7 сая төгрөгөөр тодотгон баталсан. Гүйцэтгэлээр нийт 46,519.8 сая төгрөгийн татварын ба татварын бус орлогыг төвлөрүүлж, батлагдсан төлөвлөгөөг 10,790.1 сая төгрөгөөр буюу 130,2 хувиар давуулан биелүүлсэн байна. Үүнд:

- Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын батлагдсан төлөвлөгөө 6,781.1 сая төгрөг, гүйцэтгэлээр 9,548.3 сая төгрөг төвлөрч, төлөвлөгөөний биелэлт 140,8 хувь байна.

- Сумдын орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын батлагдсан төлөвлөгөө 28,948.5 сая төгрөг, гүйцэтгэлээр 36,971.4 сая төгрөг төвлөрч, төлөвлөгөөний биелэлт 127,7 хувь байна.

Татварын орлогын төлөвлөгөө давж биелэхэд дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна. Үүнд: Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй уул уурхай, аялал жуулчлал, аж үйлдвэрлэлийн чиглэлийн аж ахуйн нэгжүүдийг салбар нэгжээр бүртгэн авсан, Төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэнээр цалингийн ашиг 4,563.1 сая төгрөг, агнуурын нөөц ашигласны төлбөр 1,363.1 сая төгрөг, хуш модны самрын ургацтай холбоотойгоор ойн төлбөр 2,537.9 сая төгрөг, татварын хувь хэмжээг нэмэгдүүлсэнтэй холбоотой үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар 3,230.1 сая төгрөг, үйл ажиллагааны орлогын албан татвар 551.9 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 750.5 сая төгрөгөөр, АТБӨЯХАТ 51.8 сая төгрөгөөр илүү төвлөрсөн байна.

Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөний биелэлтийг нэр төрлөөр авч үзэхэд газрын төлбөрийг 797,3 сая төгрөгөөр, суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татварыг 733.3 сая төгрөгөөр, малын тоо толгойн албан татвар 632.1 сая төгрөгөөр, хадгаламжийн хүүгийн орлого 182.9 сая төгрөгөөр, Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 35.2 сая төгрөгөөр, хог хаягдлын хураамж 66,794.2 сая төгрөгөөр, нийт 8 нэр төрлийн орлого 2,790.8 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Аймгийн Татварын хэлтсийн 2022 оны төсвийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийн мэдээг, Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн орон нутгийн орлогын гүйцэтгэлтэй тулгахад 2 нэр төрлийн орлого 169.3 сая төгрөгөөр илүү, 8 нэр төрлийн орлого 80.7 сая төгрөгөөр дутуу буюу аймгийн Татварын хэлтэс нь нийт дүнгээр 88.5 сая төгрөгөөр илүү мэдээлсэн байна. Мөн аймгийн Татварын хэлтсийн төсвийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийн мэдээ нь сумдын татварын байцаагч нарын гаргасан мэдээнээс зөрүүтэй нийтлэг зөрчил байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд улсын төсвөөс буюу орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 12,408.3 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 49,993.4 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого буюу зээлийн эргэн төлөлтөөс 2,370.4 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 22.6 сая нийт 64,794.7 сая төгрөг төвлөрсөн байна.

Батлагдсан төлөвлөгөөнөөс улсын төсвөөс буюу орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 115.9 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого буюу зээлийн эргэн төлөлтөөс 1,889.3 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс 15,354.0 сая төгрөг нийт 17,359.2 сая төгрөг дутуу, орон нутгийн төсвөөс 3,272.2 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 22.6 сая төгрөг нийт 3,294.8 сая төгрөгөөр илүү санхүүжигдсэн байна.

Аймгийн Засаг даргын 2022 онд зарцуулах зарлагын тодотгон батлагдсан төлөвлөгөө 78,859.2 сая төгрөг, зардлын нийт гүйцэтгэл 64,377.7 сая төгрөг буюу 14,481.5 сая төгрөгөөр дутуу зарцуулж, гүйцэтгэл 81.6 хувьтай байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар тайлант онд цалин, шимтгэлийн зардал 910.2 сая төгрөгөөр, байр ашиглахтай холбоотой тогтмол зардал 758.5 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 39.1 сая төгрөгөөр, нормативд зардал 1.6 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 14.5 сая төгрөгөөр, дотоод албан томилолтын зардал 179.5 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, төлбөр хураамжийн зардал 180.2 сая төгрөгөөр, бараа ажил үйлчилгээний бусад зардал 383.2 сая төгрөгөөр, бусад урсгал шилжүүлэг 129.0 сая төгрөгөөр, хөрөнгийн зардал 8,909.3 сая төгрөгөөр, эргэж төлөгдөх цэвэр зээл 2,406.2 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан байна.

Төсвийн зарцуулалтад бараа үйлчилгээний бусад зардал 383.3 сая төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардал 129.0 сая төгрөгөөр, хөрөнгийн зардал 8,909.4 сая төгрөгөөр, эргэж төлөгдөх зээл 744.4 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан нь төсвийн зарлагыг хэмнэхэд нөлөөлсөн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нэмэлт төсвийн дансанд тайлант хугацаанд хандив тусламжаар 421.5 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 2,857.4 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,281.3 сая төгрөг, нийт 5,560.2 сая төгрөгийн эх үүсвэр төвлөрчээ.

Энэ нь өмнөх оноос 5,006.0 сая төгрөгөөр буюу 47,4 хувиар буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төв зэрэг улсын төсвийн байгууллагууд харьяа дээд байгууллагадаа шилжсэнтэй холбоотой байна.

Хүснэгт №10 Нэмэлт дансны эх үүсвэр

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өсөлт (+), Бууралт (-)
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	360.3	421.5	61.2
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,285.5	2,857.4	-5,428.1
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,920.4	2,281.3	360.9
<b>Дүн</b>	<b>10,566.2</b>	<b>5,560.2</b>	<b>-5,006.0</b>

Эх сурвалж: Төв аймгийн ТЭЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаас

Нэмэлт санхүүжилтийн дансанд авсан хандив, тусламж 421.5 сая төгрөгийг Сэргэлэн сумын ЗДТГ нийгмийн хариуцлагын гэрээний дагуу Мөнхийн баян гал ХХК-иас 350.0 сая төгрөгийг ахуйн үйлчилгээний барилга барихад, Тэнхуа ХХК-аас Цээл сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал 12.0 сая төгрөг нутгийн удирдлагын 30 жилийн ой тэмдэглэх хүрээнд, ЗДТГ 5.0 сая төгрөгийг иргэний нээлттэй танхимын тохижилтод, Баянжаргалан сум нь сумын 100 жилийн ойг угтан 20.0 сая төгрөгийг, Сүмбэр сумын ЗДТГ нь 34.8 сая төгрөгийн хандивыг 7 аж ахуйн нэгж, 5 иргэнээс нэмэлт дансаар авч зарцуулсан байна.

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 9 дүгээр хуралдааны 3 дугаар тогтоолоор баталсан “газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдааны орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, зарцуулах, тайлагнах” журмын дагуу аймгийн Засаг даргын захирамжаар 2022 онд зохион явуулсан газрын дуудлага худалдааны орлогыг аймаг, сумдын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд хуваарилан зарцуулахаар шийдвэрлэснийг үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор тайлагнасан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд тайлант хугацаанд 5,560.2 сая төгрөгийн эх үүсвэр бүрдсэнээс 4,499.9 сая төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 1,118.6 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулалтыг зардлын зүйлээр нь авч үзэхэд цалин, шимтгэлийн зардалд 31.4 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 35.9 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 68.9 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 440.5 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 57.5 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 2,267.3 сая төгрөг, тэтгэмж шагнал урамшууллын зардалд 697.2 сая төгрөг, хөрөнгийн зардалд 901.2 сая төгрөг, нийт 4,499.9 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Энэ нь өмнөх оны зардлын гүйцэтгэл 10,018.4 сая төгрөгөөс 5,518.5 сая төгрөгөөр буюу 55,1 хувиар зардал буурсан байна.

Хүснэгт №11 Нэмэлт дансны зарцуулалт /сая төгрөг/

Зардлын үзүүлэлт	Мөнгөн дүн
Цалин хөлс, Нийгмийн даатгалын шимтгэл	31.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35.9
Хангамж, бараа материалын зардал	68.9
Эд хогшил, урсгал засварын зардал	440.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	57.5
Бараа үйлчилгээний бусад зардал	2,267.3
Тэтгэмж, шагнал, урамшууллын зардал	697.2
Хөрөнгийн зардал	901.2
<b>Зарлагын дүн</b>	<b>4,499.9</b>

Эх сурвалж: Төв аймгийн ТЕЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаас

**Харьяа байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар:**

Төсвийн шууд захирагч болон төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн газрын дуудлага худалдааны болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг төвлөрүүлээгүй зөрчилд 107.9 сая төгрөгийн төлбөрийн акт бичигдсэн.

Нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн хандивтай холбоотой 54.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага бичигдсэн.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

**3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Засгийн газрын санхүүгийн төсвийн гүйцэтгэлийн Э-тайлангийн программыг ашиглан нэгтгэсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн Санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн харьяа 64 төсөвт байгууллага, 4 хувийн өмчит сургууль, цэцэрлэг, 10 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 103 тусгай сан, 28 төрийн сангийн нэгж, 4 данс, бусад сайдын багцын 130 төсвийн байгууллага нийт 343 тайлан нэгтгэгдсэн байна. Үүнээс:

- Алтанбулаг сумын байгаль хамгаалах сан тоон мэдээлэлгүй нэгтгэгдсэн.
- Аймгийн хөрөнгийн барьцаа сан, Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Орон нутгийн хөрөнгө оруулалт, Нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлт, Засаг даргын ерөнхий данс зэрэг данс нэгтгэгдсэн байна.
- Сангийн яамны Э-тайланд 19 сумын Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сангийн санхүүгийн тайланг 17 сум Байгаль хамгаалах санд, Баян сум Мал хамгаалах санд, Баянчандмань сум орон нутгийн ерөнхий орлогын тайланд нэгтгэсэн өмнөх оны зөвлөмжөөр өгсөн зөрчлийг арилгаагүй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн 65 төсөвт байгууллага, 103 тусгай зориулалттай сан, 8 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 27 сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нийт 203 санхүүгийн тайланд аудит хийгдлээ. Жаргалант сумын Экотөв Жаргалант ОНӨААТҮГ үйл ажиллагаа явуулаагүй, Сэргэлэн, Алтанбулаг сумдад шинээр байгуулагдсан ОНӨААТҮГ-ууд нь аудит хийгдэх жагсаалтад бүртгэгдээгүй тул аудитад хамрагдаагүй байна.

Аудитад хамрагдсан 202 санхүүгийн тайлангаас 37 төсөвт байгууллага, 27 төрийн сангийн нэгж, 6 орон нутгийн өмчит байгууллагын нийт 70 санхүүгийн тайланд санал дүгнэлт гаргаж, 28 төсөвт байгууллага болон 103 тусгай сангууд, 1 орон нутгийн өмчит байгууллага, нийт 132 санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгасан. Үүнд:

- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 27 санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт гаргаснаас 96,3 хувь буюу 26 санхүүгийн нэгтгэсэн тайланд “Өөрчлөлтгүй”, 3,7 хувь буюу Баян сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгөгдсөн.
- Төсвийн шууд захирагчийн 37 санхүүгийн тайланд санал дүгнэлт гаргаснаас 91.8 хувь буюу 34 санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй”, 8,2 хувь буюу 3 байгууллагын (БаруунЗуунмод Өрхийн эрүүл мэндийн төв, Сүмбэр, Борнуур сумдын ЗДТГ-ын санхүүгийн тайланд) “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгөгдсөн.
- Орон нутгийн өмчит 6 аж ахуйн нэгж санхүүгийн тайланд санал дүгнэлт гаргаснаас 66,7 хувь буюу 4 санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй”, 33,3 хувь буюу 2 байгууллагын Төв Эрдэнэс, Заамар хөгжил ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгөгдсөн.

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, түүний харьяа байгууллагуудад хийсэн аудитаар нийт 96,972.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 62,219.5 сая төгрөгийн алдааг залруулж, 158.8 сая төгрөгийн зөрчилд 62 төлбөрийн акт тогтоож, 8,167.6 сая төгрөгийн зөрчилд 91 албан шаардлага, 23,159.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд 203 зөвлөмж өгөгдсөн байна.

Аудитаар илэрсэн зөрчлийг төсөв захирагчаар ангилбал:

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 27,214.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 22,425.4 сая төгрөгийн алдааг залруулж, 0.6 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1,803.3 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох 1 албан шаардлага, 2,984.7 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгөгдсөн.
- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 37,157.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 32,056.4 сая төгрөгийн алдааг залруулж, 57.5 сая төгрөгийн зөрчилд 10 төлбөрийн акт тогтоож, 1,959.6 сая

төгрөгийн зөрчилд 13 албан шаардлага, 3,084.4 сая төгрөгийн зөрчилд 40 зөвлөмж өгөгдсөн.

- Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 14,601.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 6,041.3 сая төгрөгийн алдааг залруулж, 91.7 сая төгрөгийн зөрчилд 41 төлбөрийн акт тогтоож, 3,767.9 сая төгрөгийн зөрчилд 53 албан шаардлага, 4,676.7 сая төгрөгийн зөрчилд 70 зөвлөмж өгөгдсөн.
- Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,256.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 348.3 сая төгрөгийн алдааг залруулж, 6.8 сая төгрөгийн зөрчилд 6 төлбөрийн акт, 757.2 сая төгрөгийн 13 албан шаардлага, 144.1 сая төгрөгийн зөрчилд 15 зөвлөмж өгөгдсөн.
- Тусгай зориулалттай сангуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 16,742.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,348.1 сая төгрөгийн алдааг залруулж, 2.2 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 1,683.1 сая төгрөгийн зөрчилд 12 албан шаардлага, 12,269.8 сая төгрөгийн алдаа, зөрчилд 76 зөвлөмж өгөгдлөө.

### **3.8 Аудитын гол асуудал**

Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан “Санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллагын жагсаалт, аудит хийх хэлбэр батлах тухай” 2021 оны А/87 дугаар тушаалын дагуу аймгийн Засаг даргын харьяа төсөвт байгууллагууд, тусгай зориулалттай сангуудын санхүүгийн тайланд хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, тусгай зориулалттай сан бүрээр төлөвлөн хэрэгжүүлж, аудитын дүн, дүгнэлтийг шалгагдагч байгууллагын удирдлагад хүргүүлэн ажиллалаа. Үүнд:

- Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудиторуд нь 27 сумын төсвийн төвлөрүүлэн захирагч, ЗДТГ, ИТХ, ОНХС, ХХС, ЭЭС, байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сангуудын санхүүгийн тайланд аудит хийж,
- Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний үндсэн дээр Ихмонгол хөлөг Аудит ХХК, Дундманхайдай Аудит ХХК-ууд нь сум дундын Ойн анги, ОНӨААТҮГ-уудын санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аймгийн Засаг дарга шилэн дансны цахим хуудсанд төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлтийг хугацаандаа байршуулсан төлөвтэй боловч хөтөлбөрийн үр дүнгийн биелэлтийг гаргаагүй, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв, өмч хөрөнгийн зарцуулалттай холбоотой шийдвэрийг бүрэн байршуулаагүй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийсэн нийцлийн аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 18,644.3 сая төгрөгийн 103 зөрчилд зөрчлийг таслан зогсоох давтан гаргахгүй байх 12 албан шаардлага, 91 зөвлөмж өгсөн байна.

#### **3.9.2 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч 2022 онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой дараах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.

Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар батлагдсан “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 204 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын 2022 оны А/617 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулж ажилласан байна.

Засгийн газрын 204 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогын судалгаанд хамрагдсан аймгийн хэмжээнд байгаа тээврийн хэрэгслийн тоо судалгаа болон татварын мэдээллийн бааз санг үндэслэн автомашин ашиглах эрх бүхий албан тушаалтнаас бусад албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа орон нутгийн өмчид бүртгэлтэй суудлын 156 автомашины жагсаалтыг гаргахад ашиглалтад хяналт тавьж ажиллах 61 автомашин байна гэсэн тооцоо судалгааг гаргасан байна.

Мөн аймгийн Засаг даргын 2022 оны А/617 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтаар "Автомашин ашиглалтын түр журам"-ын баталж гаргасан байна. Хуульд заагдсаны дагуу аймгийн хэмжээнд татан төвлөрүүлэх нэгдсэн авто бааз байхгүй тул цаашид дээрх суудлын автомашинуудыг тухайн эзэмшигч байгууллагын мэдэлд байлган ашиглалтад хяналт тавьж, хөдөлгөөнийг хязгаарлахаар ажиллаж байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасны дагуу хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах зарчмуудыг мөрдлөг болгож, зарим үйл ажиллагаанд тавьсан хязгаарлалтын хүрээнд батлагдсан төсвийг захиран зарцуулж ажиллаж байхыг төсөвт байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот байгууллагуудын дарга, нягтлан бодогч нарт чиглэл өгч хэрэгжилтийг гаргуулан авч, хяналт тавьж ажилласан байна.

Засгийн газрын 203 дугаар тогтоолыг хэрэгжилтийг хангах чиглэлээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарсан Засгийн газрын тэмдэглэл, анхаарах асуудлуудыг сумдын төрийн сан, төсөвт байгууллагуудад хүргүүлсэн байна.

Дээрх тогтоолд заасны дагуу 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс аймгийн Засаг даргын 1 орлогчийг чөлөөлсөн боловч зөвлөхөөр буцааж томилсон зөрчилд албан шаардлага бичигдсэн байна.

### **3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар өгөгдсөн 0.5 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулаагүй, 1,678.6 сая төгрөгийн албан шаардлагын хэрэгжилтийг ирүүлээгүй байна.

Аудитаар 2 зөвлөмж өгөгдсөнөөс Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, иж бүрэн олон нийтэд ойлгомжтой хэлбэрээр байршуулж хэвших, аймгийн Засаг даргын ерөнхий данснаас улс, орон нутгийн төсөвт байгууллагуудын урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг санхүүжүүлдэг байдлыг таслан зогсоож, тус дансны санхүүгийн тайланг бэлтгэж, тайлагнах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аймгийн Засаг даргын ерөнхий дансны зарцуулалт болон тус дансны санхүүгийн тайланг бэлтгэж, тайлагнах гэсэн зөвлөмжийн хэрэгжилтийг аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 05/2089 дугаартай албан бичгээр ирүүлсэн боловч аймгийн Засаг даргын ерөнхий дансны санхүүгийн тайланг бэлтгэж, тайлагнаагүй зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт №12 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	0.5	-	-	-
Албан шаардлага	8	1,678.6	-	-	-
Зөвлөмж	2	124.2	-	-	-
<b>Нийт дүн</b>	<b>11</b>	<b>1,803.3</b>	-	-	-

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Засаг даргын ерөнхий дансны зарцуулалтыг дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудлаар авч үзлээ.

## 4. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

### 4.2.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 22,425.4 сая төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 22,425.4 сая төгрөгийн алдааг залруулав.

1.Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн байдлын тайлан дахь мөнгөн хөрөнгө дансны үлдэгдлийг тулган шалгахад төрийн сан харилцах дансны үлдэгдэлд Баруун Зуунмод ӨЭМТ-ийн 58.8 сая төгрөг, Аргалан илч ОНӨААҮГ нь татан буугдсан байхад 0.01 сая төгрөгөөр арилжааны банк дахь үлдэгдэлд тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2.Төсвийн ерөнхийлөн захирагчийн бараа материалын тодруулга тайлан дахь нэмэгдсэн хасагдсан бараа материалыг тулган шалгахад Өндөрширээт сумын Засаг даргын тамгын газар 5.0 сая төгрөгөөр шилжүүлэн авсан мал амьтадыг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн авснаар тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

3. Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн авлага дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажсан эсэхийг э тайлангийн тодруулгатай тулган шалгахад нийт авлагын 68,7 хувь буюу 12,495.0 сая төгрөгийн авлага тооцоо нийлээгүй төлөвт тайлагнагдсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “жинхэнэ хэрэгжилтийн”, 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв



байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд авлага дансанд залруулга хийгдсэн байна.

4. Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн өглөг дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажсан эсэхийг э тайлангийн тодруулгатай тулган шалгахад нийт өглөгийн 23,7 хувь буюу 943.6 сая төгрөгийн өглөг тооцоо нийлээгүй төлөвт тайлагнагдсан, Төв Эрдэнэс ОНӨААТҮГ-ын байгууллагад төлөх өглөг 79.6 сая төгрөгийг хугацаа хэтэрсэн бөгөөд тооцоо нийлээгүй гадаад валютын богино хугацаат өглөгөөр тайлагнасан, улсын төсвийн байгууллага болох Лүн сумын сургуулийн 11.8 сая төгрөгийн, соёлын төвийн 22.1 сая төгрөгийн, нийт 33.9 сая төгрөгийн өглөгийг нэгтгэж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “жинхэнэ хэрэгжилтийн”, 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд өглөг дансанд залруулга хийгдсэн байна.

5. Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан дахь тайлант үеийн үр дүн санхүү байдлын тайланд 5,855.4 сая төгрөгөөр, өмч өөрчлөлтийн тайланд 14.1 сая төгрөгөөр, нэгтгэсэн санхүү байдлын тайланд өмч өөрчлөлтийн тайлангаас хөрөнгийн дахин үнэлгээний нөөц 5,9 сая төгрөгөөр, хуримтлагдсан үр дүн 4,6 сая төгрөгөөр буюу нийт 5,880.1 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “жинхэнэ хэрэгжилтийн”, 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд өглөг дансанд залруулга хийгдсэн байна.

Аудитаар нийт 4,788.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс 0.6 сая төгрөг төлбөрийн акт, 1.803.3 сая төгрөгийн хариуцлага тооцох албан шаардлага, 2,984.7 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргах байх 2 зөвлөмж хүргүүлсэн.

#### **4.2.2 Төлбөрийн акт**

Тариалан эрхлэлтийг дэмжих сан татан буугдсан, мөнгөн хөрөнгө дансанд кассын үлдэгдэл 0.6 сая төгрөг бэлэн мөнгөөр байхгүй байхад тайлагнасаар ирсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5.-д “хариуцлагатай байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “оршин байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан

“Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэсэн заалтын дагуу төлбөрийн акт тогтоов.

#### **4.2.3 Албан шаардлага**

Өмнөх аудитаар өгсөн 0.5 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 1,678.6 сая төгрөгийн 8 албан шаардлага, 124.2 сая төгрөгийн 2 зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.Төрийн аудитын байгууллага аудитын дүгнэлтэд тулгуурлан төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, бусад эрх зүйн актын хүрээнд нийтийн өмчийг төлөвлөх, хуваарилах, ашиглах, зарцуулах үйл ажиллагааны арвилан хэмнэлт, үр ашигтай, үр нөлөөтэй байдал болон төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулах зорилгоор шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтанд зөвлөмж өгнө. 20.3.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.2 Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ гэсэн заалтын дагуу албан шаардлага өгөв.

#### **4.2.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой**

###### **Илрүүлэлт:**

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны аудитлагдсан санхүүгийн нэгтгэсэн тайлангийн өглөг 7.4 сая төгрөгөөр, авлага 7.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “жинхэнэ хэрэгжилтийн”, 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “оршин байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### **Өгсөн зөвлөмж:**

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитлагдсан эцсийн үлдэгдлийг тайлант хугацааны эхний үлдэгдэлээр зөрүүгүй шилжүүлж байх

##### **2. Шилэн данстай холбоотой асуудал**

###### **Илрүүлэлт:**

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны мэдээллийг бүрэн байршуулсан эсэхийг шалгахад 2022 оны Засаг даргын захирамжаас Шилэн дансны цахим хуудасны "Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэсэнд 138 шийдвэр байршуулж 2.969,9 сая төгрөгийн 74 шийдвэрийг байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн

4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" зарчмууд хангагдахгүйгээс гадна "иж бүрэн байх", "эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, иж бүрэн олон нийтэд ойлгомжтой хэлбэрээр байршуулж хэвших

Дээрх төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
ТЕЗ	9	22,425.4			9	22,425.4	9	22,425.4		
ТТЗ	49	32,056.4			49	32,056.4	49	32,056.4		
ТШЗ	73	6,041.3			73	6,041.3	73	6,041.3		
ОНӨГ	9	348.3			9	348.3	9	348.3		
ОНТС	24	1,348.1			24	1,348.1	24	1,348.1		
<b>Дүн</b>	<b>164</b>	<b>62,219.5</b>			<b>164</b>	<b>62,219.5</b>	<b>164</b>	<b>62,219.5</b>		

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТЕЗ	3	1,818.7	1	0.6			1	14.8	1	1,803.3
ТТЗ	43	1,976.7	9	55.1	7	336.1	27	1585.5		
ТШЗ	130	4,963.4	41	91.7	39	2,342.2	50	2529.5		
ОНӨГ	24	547.6	6	6.8	9	442.2	9	98.6		
ОНТС	40	2,824.2	4	2.2	10	243.7	24	1138.9	2	1,439.4
<b>Дүн</b>	<b>240</b>	<b>12,130.6</b>	<b>61</b>	<b>156.4</b>	<b>65</b>	<b>3,364.2</b>	<b>111</b>	<b>5,367.3</b>	<b>3</b>	<b>3,242.7</b>

#### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>										
ТЕЗ	1	2,969.9					1	2,969.9		
ТТЗ	20	3,124.6	1	2.3	6	1,623.4	13	1,498.9		
ТШЗ	35	3,597.0			14	1,425.7	20	2,147.2	1	24.1
ОНӨГ	10	360.5			4	315.0	6	45.5		
ОНТС	54	12,570.3			2	1,439.4	52	11,130.9		
<b>Дүн</b>	<b>120</b>	<b>22,622.3</b>	<b>1</b>	<b>2.3</b>	<b>26</b>	<b>4803.5</b>	<b>92</b>	<b>17792.4</b>	<b>1</b>	<b>24.1</b>
<b>Нийт дүн</b>	<b>120</b>	<b>22,622.3</b>	<b>1</b>	<b>2.3</b>	<b>26</b>	<b>4803.5</b>	<b>92</b>	<b>17792.4</b>	<b>1</b>	<b>24.1</b>

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2-р байр  
Утас: +976 70272582, +976 70273465  
И-мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)